



СЭЛЭНГЭ АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-04-30 № 077 2020/04-НА-011
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020520

Дүгнэлт

Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын хорооны Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сэлэнгэ аймгийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...13... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**АЙМГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

**СҮХБААТАР СУМ
2020 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

4317143998
МЦА0065 9055436

2020.07.28

Сүхбаатар сум

**СЭЛЭНГЭ НУТГИЙН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ
“ХҮЧЭЭ НЭГТГЭЕ”**

Сэлэнгэ нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг зуун дамнан удирдаж ирсэн түүхэн уламжлал, туршлагадаа тулгуурлан Монгол Улсын хөгжлийн алсын хараа, ирээдүйн чиг хандлагыг иш үндэс болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2020 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа зохион байгуулж гардан хэрэгжүүлснээр Сэлэнгэ нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах шаардлагын үүднээс аймаг орон нутгийнхаа ард иргэд, ААН, ТББ-аас ирүүлсэн саналуудыг нэгтгэн дүгнэж, 2020-2024 онд Сэлэнгэ нутгийнхаа хөгжил, дэвшил хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж хэрэгжүүлэх гол ажил, арга хэмжээг хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө Сэлэнгэ аймгийн МАН-ын Хороо сонгогчид Та бүхэндээ өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ СОЁЛ

Боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, Сэлэнгэ аймгийн хөгжлийн суурь гэж үзнэ.


- 1.1 Бага дунд боловсролын чанар үр дүнг дээшлүүлж, сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн хяналт үнэлгээ хийдэг болно.
- 1.2 Өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, уламжлалт зан үйл сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор аймаг, орон нутгийн түүх соёл, уламжлалт зан үйл, үнэт зүйлсийн тухай мэдлэгийг сургалтын агуулгад багтаан олгоно.
- 1.3 Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сурагчдад үүргээ ухамсарлах, мэргэжлээ сонгох, ирээдүйгээ тодорхойлоход нь зөвлөж туслах чиг үүрэг бүхий “Сэтгэл зүйч мэргэжилтэн”-г сургууль бүрд ажиллуулна.
- 1.4 Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн тоо, эрэлт хэрэгцээнд уялдуулан цэцэрлэг, сургууль шинээр барих, өргөтгөх замаар бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барих, орчны стандарт хангасан хүүхэд бүрд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бий болгоно.

- 1.5 Малчин өрхийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын гэр цэцэрлэг ажиллуулж, эцэг эхчүүдийн боловсролыг дээшлүүлэх замаар тэдний оролцоонд түшиглэн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжинэ.
- 1.6 Орон нутгийн МСҮТ-ийн сургалтын хөтөлбөрийг бүс нутгийн онцлог, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулна.
- 1.7 Аймгийн төв Сүхбаатар суманд Хөдөө Аж Ахуйн их сургуулийн салбар сургууль байгуулна.
- 1.8 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 насны хүүхдийг хамруулах боломжтой болгож, яслийн үйлчилгээг сэргээнэ.
- 1.9 Ерөнхий боловсролын сургуульд өдөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.
- 1.10 Сумдын соёлын төв, номын сан, орон нутаг судлах танхимыг байнгын ажиллагаатай байлгаж, үйлчилгээний нэр төрлийг олшруулан иргэдийн соёлын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР, СПОРТ

Иргэн, гэр бүл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлж, эрүүл амьдралын хэв маягийг дэмжинэ.

- 2.1 Аймгийн хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоож урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чиглүүлнэ.
- 2.2 Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг аймгийн төвд өргөжүүлэн ажиллуулна.
- 2.3 Иргэн бүрийг жил бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 2.4 Сумдын эрүүл мэндийн төвийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг дэс дараатай тавьж, шийдвэрлүүлнэ.
- 2.5 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
- 2.6 Аймгийн нэгдсэн эмнэлгийн уламжлалт анагаах ухааны тасгийн хүчин чадал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.




- 2.7 Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлэх, техник хэрэгслээр бүрэн хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд өргөн ашиглах боломж бүрдүүлнэ.
- 2.8 Эрүүл мэндийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.9 Иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг, хийн дасгал хийх зэрэг үйлчилгээг авах бололцоо бүхий “Эрүүл зөв амьдрал” төвүүд ажиллуулах бололцоог улсын төсөв, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
- 2.10 Сум бүрд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.
- 2.11 Алслагдмал сум, баг, тосгонд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг төв суурин газрын оршин суугчидтай ижил түвшинд хүргэх “Цахим эрүүл мэнд” системд шилжинэ.
- 2.12 Аймгийн хэмжээнд бүх нийтийг хамарсан нийтийн спортын спартакиадыг 2 жил тутамд зохион байгуулж хэвшинэ.
- 2.13 Хүн ам, хүүхэд залуучуудын бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор уламжлалд үндэслэн спортын заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлнэ.
- 2.14 Аймгийн хэмжээнд цар тахлын халдвар дэлгэрэхээс сэргийлэх дэг журмыг мөрдөж хэрэгжүүлнэ.
- 2.15 Цар тахлаас үүсэх бэрхшээл, сөрөг үр дагаврыг арилгах ажил, амьдралын дотоод гадаад зохистой нөхцөлийг сэргээхэд урт, богино хугацааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг тусгайлан гаргаж мөрдөнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

- 3.1 Хувиараа болон гэр бүлээрээ ажил хөдөлмөр эрхлэх, шинэ ажлын байр бий болгохыг дэмжиж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.2 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг аймгийн онцлогт тохируулан боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамж, тусламж, дэмжлэгийг олон нийтийн оролцоотойгоор бодитой тогтоож дэмжлэгийн чанар, хүртээмжийг сайжруулна.




- 3.3 Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг дэмжихэд чиглэсэн “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 3.4 Ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүст хувиараа хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх боломжийг олгож, хаврын тариалалт, ургац хураалт, хадлан бэлтгэл зэрэг аймгийн онцлогтой ажлын үед үндсэн ажлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар дэмжлэг үзүүлнэ.
- 3.5 Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээ нэвтрүүлнэ.
- 3.6 Гадаад дотоодын төсөл хөтөлбөр, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр эмзэг бүлгийн, олон ам бүлтэй айл өрх, залуу гэр бүлийг малжуулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай таатай орчин бүрдүүлж, хот суурин газар, хөдөө орон нутгийн амьдралын чанарын ялгааг бууруулна.

- 4.1 Аймгийн төв суурин газруудын орон сууцны ногоон байгууламжийн стандартыг мөрдүүлнэ.
- 4.2 Аймаг сум, суурин газарт эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж агаар, хөрс, усны бохирдлыг багасган эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 4.3 Сүхбаатар, Мандал, Сайхан суманд инновац нэвтрүүлсэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл байгуулахыг дэмжин бүсийн сумдын хүн амыг эрүүл, аюулгүй тэжээллэг баталгаат хүнсээр хангадаг болно.
- 4.4 Хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 4.5 Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Баянгол сумдын инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлаж шинэчлэх ажлын зураг төсвийг боловсруулж, дэс дараатай шийдвэрлүүлнэ.
- 4.6 Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэн хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.7 Хот суурины хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр төслийг үе шаттай хэрэгжүүлж иргэдийн орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болгох, “Хувийн болон нийтийн орон сууц” төсөл, “Түрээсийн орон сууц” төсөл хэрэгжүүлнэ.



- 4.8 Төв суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтэц бүхий 1000 айлын орон сууцны хороолол барихад дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.9 Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.
- 4.10 Гэр хорооллын боломжтой хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох ажлыг улс аймгийн төсвөөр дэс дараатай хийж гүйцэтгэнэ.
- 4.11 Иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг хувийн эзэмшлийн газраар солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгох боломжийг судалж шийдвэрлэнэ.
- 4.12 Сэлэнгэ аймгийн болон Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Хүдэр, Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Алтанбулаг сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.
- 4.13 Төв суурин газрын усан хангамжийг нэмэгдүүлэх, шинээр барих, сэргээн засварлах хөтөлбөр төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.14 Монгол Улсын бүсчилсэн хөгжилд түүчээлэн оролцож, аймгийн дотоодын бүсийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн үргэлжлүүлнэ.
- 4.15 Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан зорчих хэсэг, дугуйн зам зогсоолыг нэмэгдүүлнэ.
- 4.16 Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангана.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Иргэн бүр ажилтай, орлоготой болох нь чинээлэг амьдралын эх үүсвэр, улс орны тогтвортой хөгжлийн суурь мөн

- 5.1 Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, шинэ үйлдвэрүүд барьж байгуулах замаар ажлын байр бий болгоно.
- 5.2 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 5.3 Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тогтолцоог өргөжүүлж зуучлалын төвүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.



- 5.4 Сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчийг санхүүгийн зах зээлтэй холбож, улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд хамруулна.
- 5.5 Орон нутгийн иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяныг үргэлжлүүлэн өрнүүлнэ.
- 5.6 Иргэд болон бизнес эрхлэгч залууст “Бизнесийн зөвлөгөө өгөх төв”-ийг аймгийн төвд байгуулна.
- 5.7 Бичил, жижиг, гарааны бизнес эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дотоодын давуу эрх олгож дэмжинэ.
- 5.8 Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцох санал санаачилгыг дэмжиж, сургалт сурталчилгаа зохион байгуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Сэлэнгэ аймаг нь аж үйлдвэр Луул уурхай/, эрчимжсэн Газар тариалан, МАА, Экологийн чиг баримжаатай олон улсын Аялал жуулчлалыг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлж, Сэлэнгэ нутгийн Брэнд болсон хүнсний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх замаар эдийн засгаа солонгоруулж, Аж үйлдвэрийн хувьсгал, Атарын 4 дэх аяныг хэрэгжүүлж улс орны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулна.

Нэг. Хөгжлийн төлөвлөлт

- 6.1.1 Сэлэнгэ аймгийн болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг “Алсын хараа – 2050” хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, төсвийн тогтвортой байдлын хуульд нийцүүлж, Сэлэнгэ нутгийн ард иргэдийн эрэлт хэрэгцээнд боловсруулж мөрддөг болно.
- 6.1.2 Дээрх зарчимд үндэслэн Сэлэнгэ аймгийн тогтвортой хөгжлийн 2021 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэн “Сэлэнгэ аймгийн хөгжил 2020-2030” бодлогын баримт бичиг боловсруулж, аймаг сумдаа алсын хараатай хөгжүүлнэ.
- 6.1.3 Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Сэлэнгэ - Илгээлтийн эзэн III” аяныг аймгийнхаа онцлогт тохируулан хэрэгжүүлнэ.
- 6.1.4 Өрхийн аж ахуйд болон хоршоодод мал бордох уламжлалт арга, үр ашигтай технологийг нэвтрүүлж, махны нөөц, хангамжийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой байлгах төсөл хэрэгжүүлнэ.
- 6.1.5 Сэлэнгийн брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Хоёр. Аж үйлдвэр

- 6.2.1 ЖДҮ-ийн салбарт олгож байгаа төрийн болон олон улсын байгууллагын зээл тусламжийн санхүүжилтийг аймагтаа татах, оролцогч талуудын уялдааг сайжруулна.
- 6.2.2 ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, мод модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох газар зэрэг ХАА, хөнгөн үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.2.3 Барилгын хийц, хэсгүүд үйлдвэрлэх төслүүдийг дэмжин хэрэгжүүлнэ.
- 6.2.4 Орон нутгийн түүхий эдэд түшиглэн Хушаат суманд “Цардуулын үйлдвэр” байгуулна.
- 6.2.5 Аймгийн төвд 50 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барина.

Гурав. Газар тариалан

- 6.3.1 Сэлэнгэ аймгийн ХАА-г цогцолбороор хөгжүүлэх, “Сэлэнгэ ХАА-н алсын хараа хүнсний зорилтот программ” боловсруулан хэрэгжүүлнэ.
- 6.3.2 Атрын IV аяныг хэрэгжүүлж, газар тариаланд орчин үеийн дэвшилтэт технологи, өндөр бүтээмжит техник нэвтрүүлэх замаар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ.
- 6.3.3 Аймгийн газар тариалангийн эргэлтийн талбайн 35 хувиас доошгүйд уринш бэлтгэж, газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана.
- 6.3.4 Тариалангийн хөрсний үржил, шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордооны хангамжийг 70 хувьд хүргэж, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлнэ.
- 6.3.5 Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх чиглэлээр тухайн эзэмшигчдийн хүлээх үүргийг өндөржүүлнэ.
- 6.3.6 Үр тарианы үрийн шилмэл сортын “Аймгийн нөөцийн сан” бүрдүүлнэ.
- 6.3.7 Төмс, байцай, лууван, сонгино, саримсны үр үйлдвэрлэх нөхцөлийг бодлого, санхүүгээр дэмжиж, үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдийг сонгон шалгаруулна.

- 6.3.8 Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, эрт ургацын ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 6.3.9 Хүлэмжийн аж ахуй, агуулах /зоорь/-ын аж ахуйг дагнан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэн, “хураалт – хадгалалт – борлуулалт”-ын сүлжээг байгуулна.
- 6.3.10 Малын тэжээл тариалалтыг таримлын сэлгээнд оруулж, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аймгийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 6.3.11 Хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй баталгаат байдлыг хангана.

Дөрөв. Мал аж ахуй

- 6.4.1 Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, гоц халдварт өвчингүй, тайван аймаг болж баталгаажуулна.
- 6.4.2 Мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын мах сүүний үйлдвэрлэл, боловсруулалтаа өсгөх, “Сэлэнгэ – Сүү”, “Сэлэнгэ – мах” төсөл хэрэгжүүлнэ.
- 6.4.3 Малын түүхий эдийг боловсруулах “Дархан” цогцолбортой түншлэл хамтын ажиллагааны гэрээ байгуулж, аймгийнхаа иргэдийн малын түүхий эдийг эргэлтэд оруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой байлгахад дэмжлэг үзүүлнэ.
- 6.4.4 “Сэлэнгэ малчин” хөтөлбөр боловсруулан эрчимжсэн МАА эрхлэхэд сургах, МАА-г бүсчлэн хөгжүүлэх зорилтот сургалтуудыг зохион байгуулж, орчин үеийн малчдын шинэ үеийг бэлтгэнэ.
- 6.4.5 Малын бэлчээр, усалгаа, тэжээл, вакцины хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, түүний хяналт, мэдээллийн тогтолцоог бий болгоно.
- 6.4.6 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээний лабораторийг Сүхбаатар суманд байгуулна.
- 6.4.7 Газар тариалангийн бүс нутагт малын тоо толгойг зохистой хэмжээнд байлгаж мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 6.4.8 Бэлчээр ашиглалтыг уламжлалт аргад үндэслэн улирлын хуваарьтай малын тоо, төрлийн харьцаанд зохицуулан ашиглаж, бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Тав. Аялал жуулчлал

Экологийн чиг баримжаатай олон улсын аялал жуулчлалыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн нэг салбар болгон хөгжүүлнэ.

- 6.5.1 “Сэлэнгэ аялал жуулчлал” аймгийн хөтөлбөрийг улс орны хөгжлийн шинэ зорилтуудтай уялдуулан олон нийтийн байгууллага, иргэдийн саналд үндэслэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 6.5.2 Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэн, аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- 6.5.3 Аялал жуулчлалын салбарын статистик тооцоо судалгааг хөтлөх аргачлалыг шинэчилж, дотоодын болон гадаадын аялагчдын тоо, орон нутгийн үйлчилгээний байгууллагуудад оруулсан орлого, худалдааны борлуулалт зэргийг нарийвчлан тооцож, эдийн засагт тухайн салбараас оруулдаг хувь хэмжээг үнэн зөвөөр тооцдог болно.
- 6.5.4 “Сайханы Хөтөл”-ийн аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтыг дуусган ашиглалтад оруулна.
- 6.5.5 Сэлэнгэ нутгийн үзэсгэлэнт байгаль, нутгийн иргэдийн оролцоонд түшиглэсэн тогтвортой эко аялал, хил дамнасан жуулчлалыг хөгжүүлэн дотоодын аялагч, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 6.5.6 “Сэлэнгэ Ардын Хувьсгал” цогцолбор байгуулж, түүхэн газруудыг сэргээн засварлаж тохижуулна.
- 6.5.7 Сүхбаатар, Зүүнхараа, Хөтөлд иргэд, хүүхэд, залуучуудын амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг хангасан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.5.8 Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, “Сэлэнгэ-аялал жуулчлал” бие даасан “Тур оператор” байгуулах санал санаачилгыг дэмжин, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.
- 6.5.9 Аялал жуулчлалын салбарт ажиллагсдыг гадаад, дотоодод сургалтад хамруулан мэргэшүүлэх, чадавхжуулах замаар аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт хүргэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН – НОГООН ХӨГЖИЛ


Байгаль эх дэлхийгээ хамгаалах, хүний үйл ажиллагаагаар учирсан хор хохирлыг арилгах, бүтээн байгуулалтын аливаа ажил юуны түрүүнд байгаль экологийг аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх түгээмэл стандартыг хэрэгжүүлнэ.

- 7.1 Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн, бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээх, малчдын дундын санг бий болгоно.
- 7.2 Айл өрхүүдийг ногоон байгууламжтай болгож, Сүхбаатар, Зүүнхараа, Хөтөл хотыг ногоон - эко хот болгон аймгийн хэмжээнд байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага дадлыг дэмжиж хөгжүүлнэ.
- 7.3 Төв суурин газрын ногоон байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж камержуулах, мод зүлэг суулгах, тохижуулах бүх нийтийн хөдөлгөөнийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоонд тулгуурлан өрнүүлнэ.
- 7.4 Аймаг, сумын төвийн гэр хорооллын дунд бохирын нэгдсэн инженерийн байгууламж байгуулах, био жорлон нэвтрүүлэх замаар хөрсний бохирдлыг багасгана.
- 7.5 Байгалийн нөөц ашигласны нөхөн төлбөрийн орлогыг байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан үндсэн зорилгоор нь үр дүнтэй ашиглаж, байгаль хамгаалах үйлсэд төрийн бус байгууллагууд, ААН-үүд, олон нийтийн оролцоог бүх талаар дэмжинэ.
- 7.6 Ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, жил бүр 1000-1200 га талбайд ойжуулалтын ажил хийнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ

Төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг нэмэгдүүлж, чирэгдэл, доголдол, хүнд сурталгүй үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж, төсвийг ил тод, олон нийтийн хяналтын дор зарцуулж тайлагнах нөхцөлийг бүрдүүлнэ.

- 8.1 Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийг соён гэгээрүүлэхэд хамтран ажиллана.
- 8.2 Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.
- 8.3 Аймаг, сумын ЗДТГ, хэлтэс агентлагийн төрийн албаны бүх томилгоог улс төрийн нам, хэсэг бүлгийн болон явцуу ашиг сонирхлоор бус, мэдлэг чадвар, ёс зүйн шалгуураар олон нийтийн хяналттай сонгон шалгаруулалт хийж, ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлаж ажиллана.
- 8.4 “Сэлэнгэ хэмнэлт”-ийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 8.5 Хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээнүүдийг цахимжуулан “Цахим гааль”, “Цахим татвар”, “Цахим иргэний бүртгэл”, “Цахим газрын харилцаа”, “Цахим эрүүл мэнд”, “Цахим боловсрол”, “Нэг иргэн – Нэг бүртгэл”




хөтөлбөр хэрэгжүүлэн төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн хална.

- 8.6 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлт, саналыг хугацаа болоогүй гэдгээр удаашруулдаг хүнд суртлыг цахимаар хянаж дүгнэдэг болно.
- 8.7 Сумын төвөөс алслагдсан багуудыг төвтэй болгож, багийн дарга нарыг иргэдийнхээ дунд ажиллаж, иргэд багаасаа төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.
- 8.8 Хүний эрхийг хамгаалах ардчиллын суурь зарчмыг тууштай хэрэгжүүлж, төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.
- 8.9 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг түр хамгаалах байр, мэдээлэл зөвлөгөөг авах төвийг сум бүрд ажиллуулна.
- 8.10 Төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг чангатгаж, төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд оновчтой, үр ашигтай зарцуулахад иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 8.11 Хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.
- 8.12 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын боломжит хувилбаруудыг олж, аймагтаа татах бодлого хэрэгжүүлнэ.
- 8.13 Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбарыг аймагтаа хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал санаачилгыг дэмжинэ.



ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙГДЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХУРААНГУЙ

2020-2024 онд Сэлэнгэ нутгийн хөгжил дэвшлийн шаардлагад нийцсэн, МАН-ын 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан дараах бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ. Үүнд:


- 9.1 Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулна.
- 9.2 Гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах зорилгын хүрээнд 800 айлын байр, түрээсийн орон сууц төслийн хүрээнд 200 айлын сууц барихад дэмжлэг үзүүлнэ.
- 9.3 Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийн ордныг /Сүхбаатар/ улсын төсөвт суулгаж, барина.



- 9.4 Аймгийн төвд 50 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барьж, ашиглалтад оруулна.
- 9.5 Сүхбаатар сумын үерийн даланг сэргээн засварлана.
- 9.6 Хөдөө аж ахуйн их сургуулийн салбар байгуулна.
- 9.7 Сүхбаатар-Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшигийн 121 км хатуу хучилттай зам барина.
- 9.8 Жавхлант, Орхон суманд спортын ордон барих санхүүжилтийг улсын төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 9.9 Сант сумын Ивэнгийн услалтын системийн даланг сэргээн шинэчилнэ.
- 9.10 Сүхбаатар сумын Олон улсын худалдааны төвийг агааржуулагчтай болгон орчныг тохижуулна.
- 9.11 Орхонтуул сумын төвийг Дархан, Эрдэнэтийн төв замтай холбох 65км хатуу хучилттай замыг барьж байгуулах ажлыг холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 9.12 Сүхбаатар сумын авто замын уулзвар, гарцуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлж, явган хүний зорчих хэсэг бүхий 3 км дугуйн зам тавих санхүүжилтийг улсын төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 9.13 Баянгол сумын төвөөр дайран өнгөрөх төв замын уулзвар дээр гэрлэн дохио, явган хүний гарцтай болгоно.
- 9.14 Мандал сумын Түнхэл тосгоны, Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны санхүүжилтийг улсын төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 9.15 Хүдэр, Ерөө, Цагааннуур сумдын соёлын төвүүдэд их засвар хийнэ.
- 9.16 Түшиг, Баруунбүрэн сумдын соёлын төвүүдэд сантехникийн засвар хийнэ.
- 9.17 Мандал сумын цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- 9.18 Түшиг сумын халаалтын зуухыг иж бүрэн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэн, хэрэглээний цэвэр устай, ариун цэврийн байгууламжтай барих ажлын санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.
- 9.19 Зүүнбүрэн сумын төвийн инженерийн шугам сүлжээг шинээр барина.
- 9.20 Түшиг суманд Нутгийн удирдлагын ордон барина.
- 9.21 Хушаат суманд соёл-спортын цогцолбор барих ажлын санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.
- 9.22 Хушаат суманд орон нутгийн түүхий эдэд түшиглэн “Цардуулын үйлдвэр” байгуулна.
- 9.23 Алтанбулаг суман дахь Ардын хувьсгалын музейг засаж тохижуулна.



- 9.24 Алтанбулаг сумыг “Сумын хөгжил” хөтөлбөрт хамруулж жишиг сум болгоно.
- 9.25 Баруунбүрэн сумыг олон улсын болон дотоодын аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутаг болгоно.



*Сэлэнгэ аймгийн МАН-ын Хорооноос 2020 оны Сэлэнгэ аймгийн ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа энэхүү хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг Сэлэнгэ нутгийн ард иргэд та бид хамтран хэрэгжүүлж, Ардын хувьсгалыг гардан хийж, Шинэ Монгол Улсын эх суурийг тавьсан өвөг дээдэс, Их бүтээн байгуулалтын он жилүүдэд эх орноо аж үйлдвэржүүлж, атар газар эзэмшин хүн ардаа хүнсээр хангах амин чухал хэрэгцээг хангаж ирсэн ахмад үеийнхээ түүхэн уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхныг хамтран бүтээхийн төлөө Сэлэнэчүүд бид **“ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”***

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

